



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 39

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1, 3.2.2, 3.2.3, 3.2.7 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уур амьсгалын өөрчлөлт, түүний хор уршиг, нөлөөлөл болон цөлжилтийг бууруулах талаар санал дүгнэлт боловсруулах чиглэлд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.
2. Үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 9 дүгээр сард багтаан батлуулж, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Ерөнхийлөгчийн Тамгын газар /Я.Содбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ

ХУУЛБАР ҮНЭН:  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Я. СОДБААТАР



2021000201



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны  
08 дугаар сарын 25-ны өдрийн 39 дугаар  
захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Уртнасан

Монгол Улсын Засгийн газрын гишүүн  
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Ажлын хэсгийн дэд ахлагч:

Ц.Пүрэвхүү

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Байгаль  
орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх

Гишүүд:

Г.Амартувшин

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын  
газрын Бодлого хэрэгжилтийн газрын дарга;

Ц.Ганхүү

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн  
газрын дарга /Зөвшилцсөнөөр/;

А.Энхбат

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур  
амьсгалын өөрчлөлтийн газрын дарга  
/Зөвшилцсөнөөр/;

Ч.Батсанкар

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны  
Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн  
удирдлагын газрын дарга /Зөвшилцсөнөөр/;

Э.Сансарбаяр

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны  
Ойн бодлого зохицуулалтын газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
/Зөвшилцсөнөөр/;

Д.Гэрэлмаа

Гадаад харилцааны яамны Олон талт хамтын  
ажиллагааны газрын захирал;

Д.Батмөнх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга /Зөвшилцсөнөөр/;

И.Батхүү

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн  
газрын дарга;

О.Алтансаруул

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын  
газрын Бодлого хэрэгжилтийн газрын Ахлах  
референт;

Б.Ундрах-Од	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Ахлах референт;
Д.Рэгдэл	ШУА-ийн Ерөнхийлөгч;
Б.Очирхуяг	МУИС-ийн захирал;
А.Бүрэнбаатар	МООНРТ-ийн Ерөнхий захирал;
А.Буянбаатар	ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн захирал.

Нарийн бичгийн дарга:

Б.Баярсайхан	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Бодлого хэрэгжилтийн газрын Ахлах референт.
--------------	---

-----oOo-----